



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2014 оны 06 сарын 12 өдөр

АКТ
Дугаар 69

Номгон

Г ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ 7

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн зээлийн хуваарилалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас "Цаглашгүй хүрд" ХХК-ийн захирал Б.Бат-Эрдэнэ "Баянхонгор бренд бүтээгдэхүүн" модон сийлбэр эдлэл үйлдвэрлэх зориулалтаар 25,0 сая хөнгөлөлттэй зээлийг 60 сарын хугацаатай, жилийн 7 хувийн хүүтэйгээр Баянхонгор аймаг дахь Хас Банкаар дамжуулан 2014 оны 12-р сарын 09-ны өдөр авч зээлийн хөрөнгөөр төсөлд тусгасан сийлбэрийн тоног төхөөрөмж, машиныг худалдан аваагүй, 2016 оны 3-р сараас хойш үйл ажиллагаа явуулаагүй байна.

Дээрх зөрчил дутагдал гаргасан нь Хас банктай зээлдэгчийн 2014.11.05-ны өдөр байгуулсан №1210012225 дугаартай зээлийн гэрээний тусгай нөхцлийн 2.7.3-т "Зээлдэгч нь зээлийн хөрөнгийг Үндсэн гэрээнд заасан зориулалтаар ашиглаагүй тохиолдолд зээлийг нэн даруй буцаан төлүүлэх эсхүл зээлийн хүүгийн хэмжээнд өөрчлөлт оруулж, тухайн үед Банкинд нийтэд зарласан бизнесийн зээлийн дээд хүүд шилжүүлнэ. Зээлийн хүүд өөрчлөлт оруулсан нь зээлийн төлбөрийн хуваарьт өөрчлөлт оруулах үндэслэл болно", мөн Аж үйлдвэрийн сайдын 2015.03.25-ны 64 дүгээр тушаалаар батлагдсан "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөнгөлөлттэй зээл олгох журам"-ын 5.5-д "Хяналт, шинжилгээ, үнэлгээний явцад илэрсэн зөрчил, дутагдлыг ажлын хэсэг газар дээр нь шийдвэрлэн ажиллах ба зээлийг зориулалт бусаар ашигласан, хууль дүрэм журам зөрчиж олгосон зэрэг нь хяналт, шалгалтын байгууллага, яамны хамтарсан ажлын хэсгийн дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд тухайн өдрөөс эхлэн уг зээлийг дамжуулан олгосон банкны арилжааны зээл рүү

2517011

шилжүүлэн Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд банкны эх үүсвэрээс бүрэн дүнгээр буцаан төвлөрүүлнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх..., Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.7 -т "... төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зээлдэгч "Цаглашгүй хүрд" ХХК нь хөнгөлөлттэй зээлийг зориулалт бусаар зарцуулсан тул 2017 оны 5 дугаар сарын 30 –ны өдрөөр зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөгдөөгүй үлдэгдэл 15624972 /Арван таван сая зургаан зуун хорин дөрвөн мянга есөн зуун далан хоёр/ төгрөгийг арилжааны банкны зээлийн хүүд шилжүүлэн, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих санд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2017 оны 07 дүгээр сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга Ж.Баттөр, жижиг, дунд үйлдвэр, ахуй үйлчилгээ, экстейшны асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Оюунцэцэг нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН:		ЗӨВШӨӨРСӨН:	
АХЛАХ АУДИТОР	А.ЦЭЭНЯМ	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН	
АУДИТОР	М.АЛТАНТУЯА	ГАЗРЫН ДАРГА	
АУДИТОР	Б.АЗБАЯР	Ж.БАТТӨР	
6417143544 БЮА0067 9007423		МЭРГЭЖИЛТЭН	
		Б.ОЮУНЦЭЦЭГ	

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангаагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас төгссөн албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахад эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2016 оны 06 сарын 12 өдөр

АКТ
Дугаар 40

Номгон

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн зээлийн хуваарилалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас "Олс, олсон бүтээгдэхүүн үйлдвэрлэх" зориулалтаар 70,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 60 сарын хугацаатай, жилийн 7 хувийн хүүтэйгээр Баянхонгор аймаг дахь Хас банкаар дамжуулан 2014 оны 9-р сарын 22-ны өдөр "Их Ганзүү" ХХК-ийн захирал Ж.Ганзул авсан боловч зээлийг зориулалтын дагуу ашиглаагүйгээс үйлдвэрлэл явуулаагүй байгаа.

Энэ нь Хас банктai зээлдэгчийн 2014.09.12-ны өдөр байгуулсан №1210011844 дугаартай зээлийн гэрээний тусгай нөхцлийн 2.7.3-т "Зээлдэгч нь зээлийн хөрөнгийг Үндсэн гэрээнд заасан зориулалтаар ашиглаагүй тохиолдолд зээлийг нэн даруй буцаан төлүүлэх эсхүл зээлийн хүүгийн хэмжээнд өөрчлөлт оруулж, тухайн үед Банкинд нийтэд зарласан бизнесийн зээлийн дээд хүүд шилжүүлнэ. Зээлийн хүүд өөрчлөлт оруулсан нь зээлийн төлбөрийн хуваарьт өөрчлөлт оруулах үндэслэл болно", мөн Аж үйлдвэрийн сайдын 2015.03.25-ны 64 дүгээр тушаалаар батлагдсан "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөнгөлөлттэй зээл олгох журам"-ын 5.5-д "Хяналт, шинжилгээ, үнэлгээний явцад илэрсэн зөрчил, дутагдлыг ажлын хэсэг газар дээр нь шийдвэрлэн ажиллах ба зээлийг зориулалт бусаар ашигласан, хууль дүрэм журам зөрчиж олгосон зэрэг нь хяналт, шалгалтын байгууллага, яамны хамтарсан ажлын хэсгийн дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд тухайн өдрөөс эхлэн уг зээлийг дамжуулан олгосон банкны арилжааны зээл рүү

2517013

шилжүүлэн Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд банкны эх үүсвэрээс бүрэн дүнгээр буцаан төвлөрүүлнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх..., Монгол улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.7 -т "... төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зээлдэгч "Их Ганзүү" ХХК нь хөнгөлөлттэй зээлийг зориулалтын бус зарцуулсан тул 2017 оны 5 дугаар сарын 30 –ны өдрөөр зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөгдөөгүй үлдэгдэл 42291666 /Дөчин хоёр сая хоёр зуун ерэн нэгэн мянга зургаан зуун зургаан/ төгрөгийг арилжааны банкны зээлийн хүүд шилжүүлэн, Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих санд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2017 оны 07 дүгээр сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга Ж.Баттөр, жижиг, дунд үйлдвэр, ахуй үйлчилгээ, экстейшны асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Оюунцэцэг нарт хариуцуулав.

АКТЫГ



АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

АУДИТОР

А.ЦЭЭНЯМ

М.АЛТАНТУЯА

Б.АЗБАЯР

ЗӨВШӨӨРСӨН:

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН

ГАЗРЫН ДАРГА

Ж.БАТТӨР

МЭРГЭЖИЛТЭН

Б.ОЮУНЦЭЦЭГ

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага нээгдүүлэхвэр эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АКТ
Дугаар 71

2017 оны 06 сарын 12 өдөр

Номгон

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн зээлийн хуваарилалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орон нутгийн ЖДҮ эрхлэгчдийг дэмжиж хөнгөлөлттэй зээл олгох зорилгоор 2007-2009 онд орон нутгийн орлогоос аймгийн Засаг дарга, Хас банкны захирал нарын байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу Хас банкин дахь Тусгай санд байршуулсан нийт 75,0 сая төгрөгт, жилийн 1.2 хувийн хүү тооцогдсоор 2017 оны 4 дүгээр сарын 30-ны байдлаар 6,9 сая төгрөгийн хүү бодогдсон ба гэрээнд хүүгийн орлогыг хэрхэн зарцуулах, ашиглах талаар тодорхой заалт байхгүй, бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг Нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ" дахь заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх..., Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.2 -т " Эрх бүхий байгууллагын шийдвэрээр орох орлогыг эрх зүйн хувьд журамлаагүй, " зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хас банкны тусгай санд байрших хүүгийн орлогын 6,9 / Зургаан сая есөн зуун мянган/ сая төгрөгийг Орон нутгийн төсвийн орлого болгож, Баянхонгор аймгийн

2517015

Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2017 оны 06 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Санхүү, Төрийн сангийн хэлтсийн дарга С.Байгалмаа, ерөнхий нягтлан бодогч Ц.Самбууням нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН:¹ АХЛАХ АУДИТОР АУДИТОР АУДИТОР А.ЦЭЭНЯМ М.АЛТАНТУЯА Б.АЗБАЯР 0117-07544 B-CA0067 8007423	ЗӨВШӨӨРСӨН: АЙМГИЙН ЗДТГ-ЫН СТСХ-ИЙН ДАРГА ЕРӨНХИЙ НЯГЛАН БОДОГЧ С.БАЙГАЛМАА Ц.САМБУУНЯМ B-CA0067 5007342
---	--

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь хялах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага нэгдүүлэхээр эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2017 оны 06 сарын 12 өдөр

АКТ
Дугаар 72

Номгон

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн зээлийн хуваарилалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Төгс төгөлдөр үйлс" ХХК-ийн захирал П.Лхагвасүрэн нь 2014 онд Баянхонгор сумын Сум хөгжүүлэх сангаас 20,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч төлөөгүй атлаа аймгийн Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас "Төмөр эдлэл, хайс хашаа үйлдвэрлэх" зориулалтаар 40,0 сая хөнгөлөлттэй зээлийг Баянхонгор аймаг дахь Хас банкнаас давхардуулан авсан зөрчил илэрлээ.

Энэ нь Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 4.2.2. "сум хөгжүүлэх сан болон жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урьд авсан зээлийн өргүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх..., Монгол улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.7 -т "... төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. "Төгс төгөлдөр үйлс" ХХК –иар Сум хөгжүүлэх сангийн 2017 оны 5 дугаар сарын 31-ны өдрийн байдлаарх зээлийн үлдэгдэл 10825091/ Арван сая найман зуун хорин таван мянга ерэн нэг/ төгрөгийг Баянхонгор сумын Сум хөгжүүлэх санд төлүүлэх.

2. Төлбөрийн актыг барагдуулсан тухай баримтыг 2017 оны 09 дүгээр сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга Ж.Баттөр, жижиг, дунд үйлдвэр, ахуй

2517017

үйлчилгээ, экстейшны асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Оюунцэцэг нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН ¹ :	ЗӨВШӨӨРСӨН:
АХЛАХ АУДИТОР <i>[signature]</i> А.ЦЭЭНЯМ	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
АУДИТОР <i>[signature]</i> М.АЛТАНТУЯА	ГАЗРЫН ДАРГА
АУДИТОР <i>[signature]</i> Б.АЗБАЯР	Ж.БАТТӨР
	МЭРГЭЖИЛТЭН
	<i>[signature]</i> Б.ОЮУНЦЭЦЭГ
	БАЯНХОНГОР СУМЫН СХС-ГИЙН
	МЭРГЭЖИЛТЭН
	Б.БУЛГАМАА
	"ТӨГС ТӨГӨЛДӨР ҮЙЛС" ХХК-ИЙН
	ЗАХИРАЛ
	Л.ЛХАГВАСҮРЭН

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д зөвсөн "Төрийн аудитын байгууллагаас төвсөн албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халэх тухай санхүүг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж зөвсн дэвүү хариуцагч албан тушаалтанд хариуцлага нэгдүүлэхээр эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.